

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ДАХЬ “ЦАГААН” ХЭМЭЭХ ҮГ ХЭЛЛЭГИЙН УТГА УЧИР

Б.Сүмбэр ӨМӨЗО

Abstract

Firstly, I am presenting a variety of contexts which have reference to the word ‘White’. You can find the usage of the word ‘white’ which has symbolic and indirect meaning such as ‘Mother’s white milk’, ‘Marble white ger’ etc in everyday Mongolian life.

Here are more examples of expressions where the word ‘white’ is used and translated directly from Mongolian. They appear as follow: ‘egg-white horse’, ‘smearless white heart’, ‘white flag with 9 supports’, ‘white moon festival’, ‘ten white karma’, ‘nine white wishes’, ‘white mouse year’, ‘red and white occurrence’, ‘go on a white path’ etc, also there is an idiom if translated direct from Mongolian ‘money white-eyes red’ which means greedy, as well as it is similar to the English idiom ‘he would sell his mother for money’, another idiom that ‘to be white’ which means to give up and let things happen, or ‘to eat white food’ which means to be a vegetarian etc.

From these examples the question arises when using the word white and it’s true meaning, why does the word ‘white’ express different abstract meanings referring to religious, custom words and attachment to Mongolian philosophy and mentality?

This article aims to explain the meaning of the word ‘white’ as used in ‘The Secret History of Mongolia’ which was written in the 13th century and is considered to have no outside influences of the real history. From our study we can say that the usage of the word white is used to express different meanings and all those meanings references to a three points being the nomadic lifestyle, Mongolian language distinction and arising mentality. In ‘The Secret History of Mongolia’ the word white has been used with several different meanings. For example we discovered the usage of the word white in:

- 19 different expressions to indicate the colour of different livestock ,
- in combination with other words to express 9 other colours,
- 8 given names with white in them,
- 3 indirect meanings using the word white.

Түлхүүр үг

Өнгө зүсэм, хэлний заншил судлал, танихуйн хэл шинжлэл;

Удиртгал

XIII зуунд Их Монгол Улс (1206-1271) байгуулж, дэлхийн түүхийг бүтээлцэж явсан Монгол үндэстэн өөрийнхөө хэлээр өөрийнхөө түүхийг бичиж тэмдэглэсэн эх сурвалжийн дотроос одоогоор олдлоод байгаа хамгийн эртнийх нь “Монголын Нууц Товчоон” (МНТ гэж товчилно) юм. Энэхүү сурвалж бичгийг 563 Хятад ханз үсгээр Монгол хэлний үгийг галиглан бичсэн учраас зарим алдаатай галигласан буюу хуучирч гээгдсэн эртний үг хэллэгийн утгыг зөв ухан ойлгож, эдгээр үг хэллэгийн цаана шингэсэн соёл заншлыг одоогийн хүмүүсийн сэтгэхүйгээр сэнхрүүлж ойлгуулах, цагийн шалгуур давж одоог хүртэл уламжилж ирсэн ёс заншилтай харьцуулан шинжилж, орхигдсон зүйлийг эрэн сурвалжлах, мартагдсан зүйлийг сэргээн нөхвөрлөх, гажуудсан зүйлийг засаж залруулах, өөрчлөн шинэчлэх нь даяаршлын эрин үеийн

хэл судлаачдын шийдэх чухал асуудал бөгөөд үүрэг мөн. Дэлхий дахинд глобалчлал хурдацтай хөгжиж байгаа энэ үед язгуур өв соёлоо хадгалан авч үлдэх явдал эн тэргүүнд тавигдаж байгаа бөгөөд бидны оршихуйн баталгаа болж байна.

“Монгол хүн гол төлөв цагаан, хөх, шар, улаан өнгийг эрхэмлэдэг зуршилтай. Монгол хүн эрт язгуураас цагаан өнгийг эрхэмлэдэг. Монгол хүн эртний Цагаан Дайчуулаас ирэлттэй тул цагаан өнгийг эрхэмд үздэг” (Бүрэнтөгс, эмх. 1999, х.229) сэтгэлгээнээс үүдэн Монголоороо сэтгэж бүтээн туурвисан гаднын соёлын нөлөө багатай гэж үзсэн, XIII-р зууны эхний хагаст бичигдсэн МНТ дахь “цагаан” хэмээх үг орсон хэллэгийн утга учрыг судлан шинжлэх сонирхол бий болсон юм. Товчооны “цагаан”-тай үг хэллэгийг нэг бүрчлэн түүвэрлэн судалж буй нь шинэлэг зүйл бөгөөд нүүдэлчин ахуй амьдралаас

урган гарсан энэ үг Монгол хүний хэл, сэтгэхүй, танихуйд хэрхэн бүрэлдэн хэлэнд тусгагдсаныг тогтоох зорилготой юм. Цаашид судалгаандаа хэлний заншил судлал болон танихуйн хэл шинжлэлийн онолын үүднээс МНТ дахь заншилт үг хэллэгийг төрөлжүүлэн ангилж, нэн дорвитой судалгаа хийхийг зорьж байна.

Судлагдсан байдал

МНТ нь Их Монгол улс (1206-1271)-ын үед “Их хуралдаа хурж, хулгана жил гуран сард, Хэрлэний Хөдөө Аралын Долоон Болдоого Шилхэнцэг хоёр зуур, ордос бууж бүхүйд бичиж” (Баяр, 2012, х.1466-1467) дууссанаас хойш Мин Улсын Хүнг Ү хаан (1368-1398)-ы эхний жилүүдэд барлагдан хэвлэгдэж, олны хүртээл болж эхэлжээ. МНТ-ны судалгаа ч тэр цагаас анх эхэлсэн гэдэг бөгөөд одоо судлагчид энэ үеийн анхан барын эхээс юм уу хожим нь хувилсан “Гү Гуанчи”-гийн дэвтэр, “Е Дэхуй”-н дэвтэр, “Чянь Дашины”-ний дэвтэр зэрэг хэдэн эхийг гол хэрэглэгдэхүүн болгож байна. Одоо энэ судалгааны хөгжсөөр 30 гаруй улс үндэстний хэлээр орчуулагдан гарч, дэлхийд түгснээр барахгүй “Олон Улсын Монгол Судлал” (IAMS)-ын хүрээнд хошуучилсаар байгаа юм.

Энэхүү түүх, уран зохиолын шинж хосолсон хорвоод хосгүй бүтээл үе үеийн эрдэмтэн судлаачдын билиг оюуныг сорьж, зүрхэн тамирыг шавхсаар иржээ. Монгол хүн Товчоог анх судалсан нь “Алтан товч”-ийн зохиогч гүүш Лувсанданзан гэж үздэг. Цэнд гүн 1917 онд “Е Дэхуй”-н дэвтрээр эх болгож анх удаа Монгол бичигт хөрвүүлсэн “Юань улсын нууц түүх”, Хуасай Дугаржав, Хаттори Широү 1939 онд Монгол бичигт хөрвүүлсэн “Монгол хэлний МНТ I боть”, Бөххэшиг 1940 онд Монгол бичигт хөрвүүлсэн “Монголын нууц тууж”, Ц. Дамдинсүрэн 1941 онд уран сайхны найруулга хийж Кириллээр хөрвүүлсэн “МНТ”, Алтан-Очир 1941 онд Монгол бичигт хөрвүүлсэн “МНТ”, Хишигбат 1941 онд Монгол бичигт хөрвүүлсэн “Монгол утгын Юань улсын нууц товчоо” зэрэг бүтээл орчин үе дэх МНТ судлалын суурийг тавьжээ. Загчид-Цэцэн болон Ё Сүнвү 1960-1961 онд Хятад хэлэнд орчуулсан “Хятад хэлэнд үсгээр тэмдэглэсэн Монгол хэлний шинээр орчуулж тайлбар хийсэн МНТ”, Дорнотив 1979 онд Хятад хэлэнд орчуулсан “Шинээр орчуулж товч тайлбарласан МНТ”, Загчид-Цэцэн 1979 онд Хятад хэлэнд орчуулсан “МНТ-ны шинэ орчуулга тайлбар”, Элдэнтэй дээрэх гурван эх дэвтрийг анх удаа ариутган шүүж Оюундалайтай хамтарч 1980 онд “МНТ-ны харгуулан

хянасан дэвтэр”, Элдэнтэй, Оюундалай, Асралт 1980 онд “МНТ-ны зарим үгийн тайлбар”, Баяр 1980 онд Хятад эх, эртний Монгол хэлний хөрвүүлэг, одоогийн бичгийн хэлний хөрвүүлэг, үсгийн галиг, Хятад үсгийн авианы толь зэргийг дагалдуулсан “МНТ”, Тайчууд Мансан 1985 онд Монгол бичигт хөрвүүлсэн “Шинээр орчуулж тайлбарласан МНТ”, Элдэнтэй, Ардаажав 1986 онд “МНТ-ны сийрүүлэл тайлбар”, Иринчин 1987 онд сонгодог Монгол бичгийн хэлбэрт сэргээсэн “МНТ-ны сэргээлт”, Ш.Гаадамба 1990 онд Кириллээр хөрвүүлсэн “МНТ”, Б.Сумъяабаатар 1990 онд «Монголын Нууц Товчоо, үсгийн галиг», Д.Цэрэнсоднам 1993 онд Монгол бичигт хөрвүүлсэн “МНТ-ны орчуулга тайлбар”, Шонхор 2002 онд сонгодог Монгол бичгийн хэлбэрт сэргээсэн “МНТ-ны сэргээлт” зэрэг эрдэмтдийн бүтээлийг товч дурдья. Олон улсын төвшинд Японы эрдэмтэн М.Нака, К.Широтори, Т.Кобаяси, М.Мураками, Ш.Озава, Германы эрдэмтэн Э.Хэниш, Оросын С.Козин, Францын П.Пеллио, Бельгийн А.Мостарт, Туркийн А.Тэмүр, Чехословакийн П.Поуха, Мажорын Л.Лигети, АНУ-ын Ф.Кливз, Австралийн И.дэРахевильз, Польшийн С.Калуженский нарыг дурдахгүй өнгөрч үл болно.

МНТ-нь судалгаа хэл, түүх, уран зохиол гэсэн гурван чиглэлээр хөгжиж ирснээ одоо зан заншил, гүн ухаан, шашин шүтлэг, анагаах ухаан, цэрэг дайн, улс төр, эдийн засаг, хууль цааз гэх мэт цар хүрээнд хөгжиж байна. Хэлний заншил судлалын хүрээнд хийгдэх тус өгүүллийн сэдэвтэй холбогдох МНТ-ны “цагаан” хэмээх үгийг тусгайлан судалсан нэг сэдэвт бүтээл маш цөөн байна. Бүрэнбат ““МНТ” дахь ‘үхэх’-ийг заасан хоёр өвөрмөц хэлцийг шинжлэх нь” гэдэг өгүүлэлдээ “цагаанаа цацваас, хард хахваас” хэмээх хэлцийн “цагаан, хар” гэх хоёр үгийн тухай өгүүлэхдээ “Энэхүү “цагаан” “хар” гэсэн үг бол ямар нэгэн тодорхой зүйлд л хязгаарлагдан сүү буюу мах (эсхүл ус)-ыг л орлон заасан биш юм. Харин, аль байдаг идээний зүйлийг хураан төлөөлж, нийтлэн заасан буюу хийсвэрлэн бөөрөнхийлж илтгэсэн үг л байх ёстой” (1995, х. 64) гэжээ. Н.Гэрэлт ““МНТ”-д гардаг ‘цагаан хар улаан шар хөх’ зэрэг үгэнд агуулагдаж байгаа өнгийн соёлын онцлогийг шинжилж үзэх нь” өгүүлэлдээ “1. “Цагаан хар” нь сайн муугийн ойлгогдохууныг илтгэж байдаг. 2. “Цагаан хар” анги давхаргын ялгааны өнгө болж байв. 3. “Цагаан хар” нь бас хүний нэр, угсаатны нэр, газар усны нэрийн зүйл дээр хэрэглэгдэж байдаг. 4. Хүч ихтэй амьтны зүйлд, ховор үнэт гөрөөсний зүйлд “хар” өнгөтэйг нь харин сайнд тоочин хэрэглэж байдаг. 5. “Цагаан хар”-д нэвтэрч орсон Хятад

соёлын нөлөө” (Гэрэлт, 2002, х.101) гэдэг таван зүйлээр тайлбарлаад “Эртний Монголчуудын сайн муугийн ойлгогдохуунаа “цагаан хар” өнгөнд агуулан илтгэдэг өнгийн соёлын зан үйл нь одоо ч гэсэн Монголчуудын сайн муугийн ойлгогдохуунаа илтгэх зан үйлд “цагаан”-ыг эрхэм дээд, ариун сайхны бэлгэдлийн өнгө болгож, “хар”-ыг ерийн, энгийн, эсхүл муу ёрын дооршаалын өнгө болгодог заншилтай байдаг дээр ч илэрч байдаг” (Гэрэлт, 2002, х.101) хэмээн өгүүлжээ. Д.Цэдэв “МНТ-ны бэлгэдэл зүй” хэмээх ганц сэдэвт зохиолдоо өнгийн бэлгэдэл, тооны бэлгэдэл, зөн совингийн бэлгэдлийг голчлон судалж, цагаан өнгийн талаар “МНТ-д хамгийн олонтаа давтагдсан өнгөний нэг бол цагаан юм. Цагаан өнгө бол сүүнийх мөн” (Цэдэв, 2002, х.105) гэж тэмдэглээд “Цагаан, хар, хөх өнгө нь эгэл ардын ёс заншлаас эхлээд төр ёсны хүндэтгэл үйлдэлд хүртээл түгээл болж байсан бэлгэдлийн өнгө юм” (Цэдэв, 2002, х.119) хэмээн дүгнэжээ. А.Пунсаг “МНТ дахь ёс заншлын судалгаа” бүтээлдээ МНТ дахь хүний нэрийн талаар маш цэгцтэй судалгаа хийж, өнгөний бэлгэдлээр нэр хайрлах тухай өгүүлэхдээ “Монгол хүний нэрд цагаан өнгөөр бэлгэдэн нэрийдэх явдал ч аль дээр үеэс уламжлал болон тогтжээ. Цагаан өнгийн бэлгэдэл нь үүсэл гарлын хувьд нарны шүтлэгтэй холбоотой хэмээн эрдэмтэд үздэг бөгөөд 13-р зуунд Монголчуудын төр ёсны бэлгэдлийн чухал агуулга болж байсан юм” (Пунсаг, 2011, х.59) хэмээн өгүүлсэн байдаг. Иймэрхүү “Нийгмийн зан заншлыг тусгасан буюу шингээсэн үгийг бүхэлд нь заншлын үг гэдэг. Заншлын үгийн хэмжээ далайц өргөн болохоор, тэр болгоныг хамран ярилцах боломжгүй. Тэгэхлээр эрдэм шинжилгээ судалгааны хүрээнд хэвшиж тогтворжин ахин дахин хэрэглэгддэг бөгөөд зан заншлын шинжээр хамгийн эш баримттай бэлэн байгаа нэг бүлэг үгсийг авч ярилцдаг” (Мандах, 2006, х.251) байна.

Судалгааны аргачлал

Эхлээд “цагаа” хэмээх үгийн язгуурын тухай шинжилж, “Хорин нэгт тайлбар толь”, “Монгол үгний тайлбар толь”, “Монгол үгсийн дүрмийн толь”, “Монгол хэлний товч тайлбар толь”, “Монгол үгсийн язгуурын толь”-д байгаа “цагаан” хэмээх үг хэллэгийн тайлбаруудыг харьцуулан шалгах, нэгтгэн дүгнэх аргаар дамжин дүн шинжилгээ хийв.

Дараа нь Өвөр Монголын эрдэмтэн Баярын хөрвүүлсэн эхээс МНТ дахь “цагаан” хэмээх үг хэллэг орсон 63, 80, 83, 87, 91, 117, 120, 129, 141, 147, 153, 167, 169, 182, 189, 202, 203,

216, 218, 239, 244-р зүйл (§244 мэтээр товчилно) хэсгийг түүвэрлэн жагсааж, эдгээр 39 үг хэллэгт 19 удаа зүсэм, 9 удаа өнгө, 8 удаа оноосон нэр, 3 удаа шилжсэн утгаар хэрэглэгдсэн онцлог шинжийг ялган тогтооход баримт цуглуулах, задлан шинжлэх, хураан дүгнэх аргийг ашиглав.

Түүний дараа нь МНТ-ны судалгааны бүтээл туурвилд энэхүү “цагаан” хэмээх 39 үг хэллэгийн талаар эрдэмтэд хэрхэн ойлгон судалсан баримт тайлбарыг цуглуулах, ишлэл зүүлт хийх, сонгон харьцуулах, үнэлэн дүгнэх аргаар жишээ баримтад тулгуурлан зохиогчийн үзэл бодлоо хуваалцахыг горилгов.

Эцэст нь нүүдэлчин ахуйд бий болсон “цагаан” хэмээх үгийн утга, шинжийг тогтоохын зэрэгцээ хүний хэл, сэтгэхүй, танихуй гурвын цогц уялдаа холбоо үгийн утгад хэрхэн нөлөөлөхийг ерөнхийлөн дүгнэв.

Нэг.

Үгийн гарал бүтээврийн талаас цагаан хэмээх үг нь “Монгол үгсийн язгуурын толь”-д “Ца: цагаан гэх үгийн язгуур, цагаан, саарал, цаа буга. Цагаан, цайхын ‘ца’ язгуур орчин цагийн Монгол хэлэнд зөвхөн цаа буга гэх үгэнд хадгалагдаж бий. Ц болон С авианы сэлгэцээр саарал үүснэ” (Цэцэнцогт, 1988, х.2164-2165) гэж тайлбарласан бол М.Базаррагчаа “Авианы утгын хувьд Ц авиа нь тал тал тийшээ чиглэх, Ч авиа нь нэг тийш чиглэх, ялгарах утгатай. ...цагаа (нялх балчир) нь цагаан сэтгэлтэй гэсэн ухагдахуунаас үүсжээ. Ц нь Т-гээр сэлгээд тахаалай (нар салхинд цагаан халтар болсныг хэлнэ), цахуулай (саарал зүсмийн шувуу) үүсэх, цагаа нь байраа сэлгээд хаца (хацар) болж: хажуу, хажайх, гажайх үүсчээ. ...хөдөө хээрийн эрүүл салхинд хацар нүүр нь холцруутан халтардсан үрээ цагаа хэмээн бодож, өрөвдөж, холцруу болсон хацрыг нь үнэрлэн энхрийлэхтэй холбоотой” (Базаррагчаа, 1995, х.V-VI) бөгөөд “Цар хэмээх овор хэмжээ заасан үгэнд –сун бүтээвэр залгаж царсун, царсу (том сүрлэг мод) үүсэх. Р нь гэгдээд цасун (цас) болох, гагцхүү цас, цар гэх үгийн Ц язгуур нь цайх, цагаарах гэсэн утгатай. Ус чигтэй юм хөлдөхөөрөө цайруу өнгөтэй болдог: цагаан, цайх, цийх, цэлийх, цэгийх, тарайх, тэрэйх (хөлдөх, царцах гэсэн утгатай)” (Базаррагчаа, 1995, х.X) гэх мэтийн сэлгэцэл үүсдэг хэмээн тайлбарлажээ.

“Хорин нэгт тайлбар толь”-д “Цагаан: Арван ишийн дотоод нэгэн зүйл. Цэгээн өнгийг цагаан хэмээмүй. Цав цагаан морийг цагаан морь хэмээмүй. Хүн их зэрэг гараагүйг ану цагаан хэмээмүй. Их зэрэг гараагүй хүүхдийг цагаан хэмээмүй. Бэлэвсрэлд өмсөх цагаан

бөсийн хувцас, унжлага бүсийг цагаан хэмээмүй. Сугарыг (сугар гараг) бас цагаан хэмээмүй. Цагаан эмгэн: Хүүхэд сувилахуйд залбиран гуйх хувилгааныг цагаан эмгэн хэмээмүй. Цагаан өмөсмүй: Цагаан өмсөхийг цагаан өмсөмүй хэмээмүй. Цагаан уураг: Өндөгний дотоод цагааныг ану цагаан уураг хэмээмүй. Цагаан харавч: Ханцуй адил үйлдэж тушам хадаас хадаж өмөсхүйг ину цагаан хэмээмүй. Цагаан хэрэм: Хязгаар болгон байгуулсныг ану цагаан хэрэм хэмээмүй. Цагаан мах: Хошгиногийн түрүүг цагаан мах хэмээмүй. Цагаан сар: Арван хоёр сарын тэргүүний сарыг цагаан сар хэмээмүй. Хаврын тэргүүн сарыг цагаан сар хэмээмүй. Цагаан шүүдэр: Намрын хугасын урьд буусныг ану цагаан шүүдэр хэмээмүй” (1979, х.744-746) гэх мэт үгэнд тайлбар хийжээ.

“Монгол үгсийн дүрмийн толь”-д “Цагаан: Өнгө. Цагаан үйл: сайн үйл. Цагаан үсэг: Галиггүй үсэг. Цагаан бал: Балын нэгэн зүйл. Цагаан бичиг: Дан цагаан үгсийн бичиг. Цагаан будаа: Тутарга. Цагаан бурам: Идээн. Цагаан хүн: Их зэрэгт болоогүй хүн. Цагаан газар: Уул модгүй газар. Цагаан гурил: Буудайн түүхий гурил. Цагаан тамхи: Үнстэй тамхи. Цагаан талх: Нарийн гурилын талх. Цагаан тос: Идээн. Цагаан толгой: Үгсийн. Цагаан цэцгий: Нүдний цагаан. Цагаан санаатай: Санаа сайн. Цагаан самсаа: Зүрийн сүүлийн хажуу дахь цагаан үс. Цагаан сар: Бар сар. Цагаан сэтгэлтэй: Цагаан санаатай. Цагаан шуудай бүс: Бэлэвсрэлийн бүс. Цагаан алаг: Зүсэм. Цагаан эрээн: Өнгө. Цагаан бор: Зүсэм. Цагаан буурал: Зүсэм. Цагаан саарал: Зүсэм” (Шагж, 1997, х.713-715) гэх мэтээр тайлбарлажээ.

“Монгол үгний тайлбар толь”-д “Цагаан: Лавай ба цасны өнгө мэтийн өнгөт, бас их зэрэгт хүрээгүй хүнийг, бас бэлэвсрэлд өмсөх цагаан бөсийн дээл бүс ба унжлагыг, бас аргын төмрийг, бас сугар гарагийг, бас чилбанг цагаан хэмээхэд хэрэглэмүй, бас морины цэв цэгээнийг ину. Цагаан арслан: Хувилгаан гөрөөсний нэр, хэлэлцэн төсөөлмүй, түмэн бодисын сэтгэлийг ухамуй. Цагаан үүр: Далайн захаарх хараацай зарам загасны зэргийг бөөрөнхийлж үүр хиймүй, үүнийг зууш хийж идвээс болмуй. Цагаан идээн: Сүү, тараг, айраг, өрөм, ааруул, ээзгий, хурууд, цагаа, аарцны зэргийн сүүгээр хийсэн аливаа идээнийг. Цагаан хорхой: Хүний хэвлийн дотоодоос гарах, өнгө цагаавтархан болоод хавтгай, урт нэг хуруу орчныг ину. Цагаан шонхор: Шонхроос их болоод арын чандар цав цайм цэгээнийг ину” (Шагж, 1994, х.755-758) гэх мэт үгсийн тайлбар байдаг.

“Монгол хэлний товч талбар толь”-д “1.

Юмны цас мэт өнгө, цэгээн. Цагаан бүрээ: Дун. Цагаан архи: Тариагаар нэрж үйлдсэн нэгэн зүйл хатуу архи. Цагаан хоолой: Мөгөөрсөн хоолой. Гэгээн цагаан өдөр: Тунгалаг сайхан өдөр, харанхуй биш цаг. Цагаан тос: Өрмийн шар тосыг ялгаж аваад үлдсэн хувьд ээзгий зэргийн холио хийсэн нэгэн зүйл идээ. 2. Хэцүү биш, амар хялбар. Цагаан үсэг: Уншихад хялбар үсэг. Цагаан толгой: Тухайн бичиг үсэгт сурах бүгд үсэг. Цагаан бичиг/хуудас: Тамга тэмдэг дараагүй албан бичиг. Цагаан газар: Уул хад, модгүй саруул тал газар буюу бартаагүй газар. Цагаан зам: Бартаа саадгүй сайхан шулуун зам. Цагаан ханиад/томуу: Аюул багатай хөнгөн ханиад өвчин. 3. Шударга, сайн, ариун, үнэнч. Цагаан санаа/сэтгэл: Бусдад хар хоргүй сайхан санаа. Арван цагаан буян: Арван хар нүглийн эсрэг арван сайн үйл. Цагаан хүн: Сайхан цайлган санаатай хүн. Цагаан бурхан/цэцэг: Их зэрэг сувилах буюу Бодоо өвчний цээрлэсэн нэр. Цагаан тэмээцэх: Хүүхэд багачуудын наадах тоглоом, хэдэн хүүхэд нийлж нэгийг нь буур, нөгөөг ботго гэж нэрлэж, бусад нь ботгыг хүрээлэнэ, буур нь ботгыг барих гэж тойрч зав чөлөөг эрэлхийлэн хөөж наадна” (Цэвэл, 1966, х.777-779) гэх мэтийн үг хэллэгт тайлбар хийжээ.

“Монгол үгсийн язгуурын толь”-д “1. Цас, сүүний адил өнгө. Аг ч гэдэг. 2. Ишийн долдугаар. 3. Билгийн улирлын нэгдүгээр сар. 4. Шулуун шударга, үнэнч цагаавар ба сайн сайхны бэлгэ тэмдэг. 5. Бэрх бартаагүй хялбар дөхөм, амар. 6. Тэрс намтан, этгээд гажуу. 7. Хүн үхсэн, бэлэвсрэл бүхий. 8. Үнэн зөв. 9. Цагаан будаа, цайруулсан будаа. 10. Цагаан идээ буюу өөх. 11. Хошигног. 12. Улаан нуун, цэцэг өвчин” (Цэцэнцогт, 1988, х.2169-2170) гэх мэтээр тайлбарласан байдаг.

Толь бичиг дэх зарим үг хэллэгийн товч, дэлгэрэнгүй давхардсан хувилбарыг орхиж, өвөрмөц этгээд тайлбар хийсэн хувилбарыг үлдээн, эдгээр үг хэллэгт задлан шинжлэл хийж, хураангуйлан дүгнэвэл “цагаан” хэмээх үг голцуу өнгө зүс (зүсэм) заасан тэмдэг нэрийн үндсэн шинжээр цагаан уураг, цагаан өмөсмүй, цагаан саарал, цагаан алаг гэх мэтээр хэрэглэгдэж байхаас гадна оноосон нэрээр цагаан шүүдэр, цагаан сар, цагаан бурхан гэх мэт, бас цагаан санаатай, цагаан хүн, цагаан үйл гэх мэтээр утга шилжиж, сайн сайхан, үнэнч шударга, амар хялбар, баяр бахдал, үхэл хагацал зэрэг бэлгэдэл утгыг давхар агуулсныг мэдэж болно.

Хоёр.

Доор Баярын хөрвүүлсэн МНТ-ны эхээс “цагаан” хэмээх үг хэллэгийг сийрүүлэн авч үзье: §63 “... Цагаан (1-р тохиолдол, 1 гэж

товчилдо, цонхор наран, сар хоёрыг атган нисэж ирж гар дээр мину туув(суув). Эдүгээ энэ шонхор атгаж авчирж, гартурмину туув, цагаан (2). буув. (2012, х.99-100)

§80 “... Бас гарч айсахуйдур шугуйн амсараа хошлогийн төдий цагаан (3). гүр амсараа бөглөн унажу.тэр амсар бөглөн унасан хошлогийн төдий цагаан (4). гүр орчин гарваас үл болох, ...Тайчууд сахиж ажуу. Барьж авч одов.” (2012, х.163)

§83 “...Сорхон Шар бас өгүүллрүүн: “Тайчууд хөвүүд та гэгээн, цагаан (5). өдөр хөвчин хүмүүн алдав.” (2012, х.174)

§87 “...Эдүгээ эхээ, дүү нараа эрэн од” хэмээж, ам, цагаан (6). эрмэг хулагчныг унуулж,” (2012, х.186)

§91 “... Нэгэн цагаан (7). морьт хүмүүн уурга барьж гагцаар гүйцэж айсуу. Тэр цагаан (8). морьт хүмүүн уургаараан дохиж байв.” (2012, х.200)

§117 “...Дайр Усуны хөө эвэрт, үнүхүн (орнхун) цагааныг (9) Тэмүжинээ унуулбай.” (2012, х.337-338)

§120 “...Нэгүдэй, Цагаан (10). Ува ирвэй хөө. Олхунуудын Хингияадай, Горлосоос Сэчигүр, Дөрбэнээс Мөнчбэдүүн ирвэй хөө.” (2012, х.353)

§129 “...Чиносын хөвүүдийг Далан Тогоод буцалгаж, Нэгүдэй Цагаан (11). Увагийн тэргүүнү огтолж морины сүүлдур чирч одчухуй.” (2012, х.403)

§141 “...Горлосын Чонаг Цагаан (12) тэргүүтэн, Найманаас Хүчүгүд, Жамухыг тэнд Гүр хан өргөвэй.” (2012, х.460)

§147 “... “...миний зэвлэх ам, цагаан (13) худын аман нурууг инухугахэн харвалаа уулан дээрээс?” ... “... Мөн зэвлэх ам, цагаан (14) худыг мину аман нуруу харвасны тул Зэв нэрийдэж зэвлэе имай” Зэв Тайчуудаас ирж нөхөцсөн ёсон тийм.” (2012, х.501-506)

§153 “...нохой жил намар ину Чингис хаан Цагаан (15). тагаар, Алчи татаар, Дутагүт татаар, Архуй татаар Татаарыг хөдөлгөвэй.” (2012, х.545-547)

§167 “... Үнэн бээр хан эцэг чамайг цагаанаа (16). цацваас, хард хавхаас Хэнээ бээр яахан мэдүүлэх?” хэмээжүхүй.” (2012, х.608)

§169 “...Нарин Гэгээн бас адуучдаан Хишилигээ өгүүллрүүн: “Мэргидэй цагаан (17), аман цагаан (18), хээр хоёрыг барьж авчир.Мэргидэй, цагаан (19), аман цагаан (20), хээр хоёрыг барьж ирж уяж,Мэргидэйцагаан (21), аман цагаан

(22), хээр хоёр бэлэн уягсадыг унаж, Мэргидэйцагаан (23), аман цагаан (24) хээр хоёр агтас барьж уя хэмээсэн үгс бүгдийг өгүүлж өгөвэй.” (2012, х.620-623)

§182 “... Тэнд буухуйдур, Чоғорс Цагаан (25) Горулас(Горлосын Чонаг Цагааны алдаатай бичлэг байж мэдэнэ) зөв тэнд учралдвай.Онгудын Алахуш Дигид Хориас Асан Сартагтай цагаан (26) тэмээт мянган иргэс тууж,Балжунаа услан орохуйдор учрав”. (2012, х.731-732)

§189 “...тэргүү инү огтлож авчруулж таньж, цагаан (27) толог дээр тавьж, ...тайжухуй.” (2012, х.769-770)

§202 “...барс жил Ононы тэргүүнээ хурж ёсөн хөлт цагаан (28) түг байгуулаад,Жэтэй, Тахай, Цагаан (29). Ува, Алаг, Сорхон Шар, ...ерэн таван мянгадын ноёд болов”. (2012, х.933-942)

§203 “...Бас “Гүр иргэний хувь хувилсныг зарга заргалсныг хөх дэвтэрбичиг бичиж дэвтэрлэж, ургийн урагаа хүртэл Шихи Хутугугийн надад эетэж ёсолж хөх бичиг цагаан (30) цагаалсанд дэвтэрлэснийг бүү егүүтгэтүгэйе! Егүүтгэхүн аран алдалтан болтугай» хэмээн зарлиг болов.” (2012, х.952-953)

§216 “... Бэхи өргөөд цагаан (31). дээд өмсөж, цагаан (32) агт унуулж,хэмээн зарлиг болов”. (2012, х.1035-1036)

§218 “Бас Чингис хаан, Цагаан (33). Ува-гийн хөвүүн Нарин Тоорилоо өгүүллрүүн: “Эцэг чинү Цагаан (34). Ува миний өмнө хичээж хатгалдах болон Далан Балжуд та хатгалдахуйдур Жамухада алагдлуугаа.” (2012, 1038)

§239 “...Хиргисүүдийн ноёд элсэн орж, цагаа нууд (35) цонхууд цагаа нууд (36) агтас хар нууд булгад аваад ирж Жочида уулзав.Чингис хаандор цагаа нууд (37) цонхуудаар цагаа нууд (38) агтасаар хар нууд булгадаар уулзуулвай.” (2012, х.1142-1144)

§244 “...Эх мэдээд шөнө бөгөөд удааран цагаан (39) тэмээ хөлж харгуутай тэрэгтэй шөнөд дүлин зорчиж,Чингис хаан гээгэж эхээс эмээв.” (2012, х.1170-1171)

Дээрх “цагаан” хэмээх үг хэллэгт дараах байдлаар ажиглалт хийлээ.

1. үндсэн өнгө заасан үг хэллэг нь “цагаан шонхор” 3 удаа, “цагаан гүр” 2 удаа, “цагаан толог”, “есөн хөлт цагаан туг”, “цагаан цагаалсан”, “цагаан дээл” тус тус 1 удаа

- илэрч, давхардсан тоогоор 9 удаа гарч байна.
2. Малын зүсэм заасан тохиолдол нь “ам цагаан эрмэг хулагч” , “цагаан морьт хүмүүн”, “эвэрт үнүхүн цагаан” тус тус 1 удаа, “ам цагаан хул” 3 удаа, “Мэргидэй цагаан” 4 удаа, “аман цагаан хээр” 4 удаа, “цагаан тэмээ” 2 удаа, “цагаан агт” 3 удаа давтан илэрч, энэ 8 хэллэгт 19 удаа хэрэглэгдсэн байна.
 3. Оноосон нэр, хүний нэр болж хэрэглэгдсэн нь “Цагаан-Ува” 5 удаа, “Чогос (Цонаг) Цагаан” 2 удаа, “Цагаан Татаар” 1 удаа илэрч давхардсан тоогоор 8 удаа.
 4. Шилжсэн утгаар “цагаан буув”, “гэгээн цагаан өдөр”, “цагаанаа цацваас хард хахваас” тус тус 1 удаа илэрч, нийт 3 удаа хэрэглэгджээ. “Цагаан” хэмээх үг нийт 39 удаа хэрэглэгдэж байна.

Гурав.

1. Үндсэн өнгө заасан зүйлд Хиад Боржигин овгийн сүлд тотем болох шонхор шувуу нь наран сарыг атган нисэж ирснээр дүрсэлсэн явдал бол “Шонхор шувууг мөн “тэнгэрийн шувуу”-аар ойлгож байсны баримт” (Дэлгэр, Одон, 2011, х.237) болох бөгөөд Хиад Боржигин овог нь хамаг Монголын доторх ноёрхогчид байсантай холбоотой юм. “Хорин нэгт тайлбар толь”-д “Шонхрыг харцгайд адил болоод бүргэд мэт их, ганцхүү бахан нарин, ой дотор амуй” (1979, х.606) гэж тайлбарлажээ. Шонхор, харцгай, бүргэд, тас нь цөм дайчин шаламгай, эр зоригтой махчин шувууд байдаг ч тэр дундаас шонхор шувуу тотем шүтлэг болж чадсан нь түүний биед ургасан өд сөдийн цагаан өнгө холбогдолтой байсанд оршино. Бас түүнийг Боржигин овгийн язгууртанд бэлэг сэлт болгон хүргүүлэн төв ихэмсэг, эрхэм дээд, зэрэг хэргэмийн илэрхийлэл болгож байжээ. Иймээс “Тотемшсмын дүрэмд овог аймгийн амьдран оршихуйд хэрэгцээ бүхий амьтан ургамлыг шүтэхээс гадна, бас гоо таашаалын хувьд гоо сэрэгдлийг ихээр нөлөөлдөг зарим адуус амьтны ч тотем болгон шүтдэг үзэгдэл олон бий. ...Хиад ястан голдуу гоо таашаалын хувиар Монголчуудын эрхэмлэдэг цагаан өнгөтэй ижил төсөө шонхор шувууг тотем болгон шүтэж байсан” (Сайн, 1990, х.149-151) гэдэг нь бодит үнэн юм.

Гүр гэдгийг эрдэмтэд чулуу хэмээн тайлж, балар эртний хүмүүсийн чулууны шүтлэгтэй холбон тайлбарласантай санал нэг байна. Тэмүжиний шугуйгаас гарах замыг цагаан өнгий чулуу бөглөсөн явдлыг эерэг дохио тэмдэг хэмээн ойлгож байсан учраас цагаан өнгө нь сайн сайхан зүйл, эерэг зөв үйлийн илрэл болж байна. Харин өөр тохиолдолд §147-гийн Зэвийн

андгай тангаргийн үгэнд “хөх гүр”, “хар гүр” гэж дүрслэгддэг юм.

Толог гэдэг нь эсгийн төрлийн эд хэрэгслийн нэрийдэл байжээ. Хонь малын цагаан өнгийн үс ноосоор зулж татсан эсгийг одоо ч гэсэн зарим зан үйлд эрхэмлэн дээдэлж үйлдсээр байгаа нь гэрийн туурга бүрээсийг цагаан эсгийгээр хийх, шинэ бэр мордож хадмындаа ирэхэд цагаан эсгий дээр угтан тосож буулгах, талийгаачийг цагаан эсгийд боож нутаглуулах гэх мэт ёс уламжлалд хадгалагдан үлджээ. Хэрэйд аймгийн ахлагч Ван ханы толгойг цагаан толог дээр тавин тайлга тахилга үүсгэж байгаа тэмдэглэл нь хэдийгээр эртний хүмүүсийн оршуулгын зан үйлтэй холбоотой мэдээлэл боловч түүний дотроос цагаан өнгийн эсгийг сонгож зан үйлдээ хэрэглэж байгаа явдал бол нийгмийн язгуур давхарга, хүндлэл бишрэл, ариун чанарын илэрхийлэл болж байгаа юм.

Цагаан цаасан дээр хар үсгээр бичиж, хөх дэвтэр болгон үйлдэх нь Монгол хүний ертөнцийг үзэх үзэлд хар цагаан өнгийн эсрэгцэл нэгдлээс, даруй гэрэл сүүдэр буюу өдөр шөнө хоёрын солигдол—эр эм бэлэг чанараас хорвоо ертөнц бүрэлдэн тогтнож, тэнгэр газрын дунд мөнх орших гэсэн сэтгэхүй, танихуйн ойлголтоос үүдэлтэй гүн ухааны үзэл баримтлал шингэж байгаа билээ.

Есөн хөлт цагаан туг байгуулан, төр улсаа тунхаглаж байгаа зан үйл нь Монголчуудын галын шүтлэг, тэнгэр шүтлэг, бөөгийн 99 онгод тэнгэрийн есийн тооны бэлгэдлийн ёс уламжлалын дагуу сүр хүч, онгон дагшин, мөнх орших, эснин мандахын илэрхийлэл хэмээн үзвэл цагаан өнгө нь аз жаргал, энх тайван, хүндэтгэл бишрэлийн бэлгэдэл болж байна. Энэ тухай “МНТ дахь ёс заншил зан үйлийн тайлбар толь”-д “Есөн хөлт цагаан туг нь Монгол төрийн сүлд туг болох юм. Туг сүлд бол нэг улс үндэстний бэлгэ тэмдэг, сүр хүч, итгэл бишрэл, зориг санаа, хүсэл тэмүүлэл, хишиг буян бүхий бэлгэдэл билээ. цагаан өнгө нь Монголчуудын бэлгэдлийн соёлд ариун дархан, эв найрамдал, баяр жаргал, сайн сайхан, өөд эсрэг зэрэг олон талын баялаг агуулгатай байдаг. ...есөн хөлт цагаан тугыг түүхэн сурвалжид “есөн хөлт”, “есөн хөхөлт” хэмээн хоёр янзаар бичиж тэмдэглэсэн боловч туг сүлдийн хувьд ижилхэн утгатай юм. Өөрөөр хэлбэл, хөл буюу хөхөл гэдэг нь тугийн цар хүрээг чимж унжуулсан цацаг бүхий есөн ширхэг (туг) манжилгыг зааж байна. Туг сүлдийн үндсэн бүтэц нь өнгийн хувьд цагаан, галын сорыг бэлгэдсэн сэрээ хэлбэрийн жадтай, дугуй хэлбэрийн цар хүрээтэй бөгөөд түүнээс ес буюу ес есөн наян нэгэн цагаан азарганы хөхлөөр чимж хийсэн хөл

унжуулсан хэлбэртэй байдаг. Сэрээ хэлбэр нь галын сорыг бэлгэдэж, гал шиг бадран хөгжихийг илтгэж байна. Есийн тоо нь “есөн хэлтэн иргэд” энх тавтай, эв найрамдалтай амьдрахыг бэлгэдэж байна. Сүлдийн цар хүрээг дугуй хэлбэртэй зохиож, цагаан азарганы хөхлөөр чимж бүтээсэн нь бөмбөрцөг дэлхий амар амгалан, бат бэх байхыг зөгнөж байгаа билээ” (Пунсаг, 2013, х.265-266) хэмээх тайлбартай санал нэг байна.

Баарин аймгийн Усан Өвгөнд соёрхол хайрлаж, эрт дээдээс уламжлалтай зан үйлийг мөрдөн Бэхи ноён өргөмжлөн цагаан дээл өмсгөж, цагаан агт унуулан хүндлэл үйлдэж байгаа зан үйлд цагаан өнгө нь их эртний үеэс хамгийн илүү эрхэмлэн дээдлэгдэж, хүндлэл бишрэл, ариун дархан, эрхэм тушаал, эв нэгдэл, цагаан үйл дэлгэрэн булт үйлс бүтэх бэлгэдлийн шинжийг хадгалж байсны нэгэн баримт болно.

Монголчууд цагаан өнгийг эрхэмлэн дээдэлдгийн учир холбогдол нь чухам юунаас болсон бэ? Байгаль ертөнц, ан амьтад, хүн нийгмийн харьцаан дахь танихуйн үйл ажиллагаа нь нүүдэлчдийн амьдрал, ёс заншилтай зайлшгүй холбоо хамааралтай. Малчин хүн өдөр тутмын хоол хүнсэндээ таван хошуу малынхаа мах сүүг голлон хэрэглэж, махны төрлийн хоолыг Улаан Идээ гэж нэрлээд хүйтэн хатуу өвлийг өнөтэй давахын тулд хэрэглэдэг байсан бол малын сүү цагаагаа дөч тавиад төрөл зүйлээр боловсруулж, Цагаан Идээгээ хавар, зун, намрын улиралд хүнсэндээ эрхэмлэн хэрэглэсээр иржээ. Сүүгээр боловсруулсан цагаан идээ нь нүүдэлчдийн амьдралд өдөр тутмын хоол хүнсэнд хэрэглэхээс гадна төр гүрний хүндэтгэлийн тайлга тахилга, найр хуримд дутагдаж болшгүй эрхэм чухалд тооцсоор хэвшилуламжлал болон тогтжээ. МНТ-д “Бурхан Халдуныг манагар бүр талиасугай! Өдөр бүр өчсүгэй! Ургийн ураг мину ухтугай!наран зүг есөнтөө сөгдөж цацал өчүүл өгөв” (Баяр, 2002, х.248-251) (§103) гэж, “Арван буянт номын цагаан түүх”-д “Монголчуудын дөрвөн цагийн хуримын тухай өгүүлэхдээ хаврын эцэс өгөлжин сарын хорин нэгнээ Чингис хаан ер есөн гүүгээ уяж, цагаан цацлаа цацсанаар хаврын цагаан сүргийн хуримыг тэр өдөр үйлдэх. Зуны дунд морин сарын арван зургаанаа ертөнцийн шүтээн дэлгэр эх тунагийг тавьж ер есөн цагаагчдын уураг үрсийг гаргаснаар зуны нуурын хуримыг тэр өдөр үйлдэх. Намрын эцэс нохой сарын арван хоёрноо унаганы чагт шилвиг эвхсэнээр ногт сэрэхийн (шөргө) хуримыг тэр өдөр үйлдэх. Өвлийн дунд хулгана сарын хугас шинэд Чингис хаан мялаалгуудыг хийснээр өвлийн тасам тавихуйн хуримыг тэр өдөр үйлдэх” (Лиү

Жинсүө⁶, эмх. 1980, х.87) хэмээн тэмдэглэжээ. Үүнээс гадна “Болор эрих”, “Эрдэнэ эрих”, “Юан улсын судар” гэх мэтийн сурвалж бичгүүдэд иймэрхүү тэмдэглэл олон байдаг.

Эхийн сүү нь нялх үр төлийн өсөн төлжихөд юугаар ч орлуулашгүй охь шим болж байдаг учраас эхийн сүүний тухайд өв их уламжлалтай Монголчууд эрт дээр үеэс эрхэмлэн дээдэлсээр ирсний баримтыг МНТ-д “Эх хилэгнэж уураа даран ядан, завилан сууж, хоёр хөхдөөн гаргаж хоёр өвдөг дээгүүрээ бяшруулж өгүүлрүүн: (үзэвүү? Хөхсөн хөхөн тану энэ бий.Тэмүжин энэ нэгэн хөх минь барах бүлгээ. Хачуун Одчгин хоёул болж нэгэн хөх үл барах бөлгөө. Хасар бүрэн хоёр бүр хөхөд минь барж, цээж минь агуу болтол амарлиулаж, цээж агуу болгох бүлгээ)” (Баяр, 2012, х.1172-1174) (§244) хэмээн Өгээлүн эхээс Чингис хааныг дондон сургаж байгаа болон “Богд хатан эх юүгээн тосон дуран хоруулж сүүн зүрхэн эдүүлж өгүүлмүй чи! Бүлээнээс бүлт, мөн хэвлийгээс эс үү төрлэй та? Халуунаас халт, ганц хагунагаас эс үү гарлаа та? Зүрхнээс төрсөн эх юүгээ чаматгаваас, чанар ину зэхийрч залируулбаас үл боль; Хэвлийгээс төрсөн эх юүгээ гэмрүүлбээс, гэнүгэр ину гэгсгээвээс үл боль” (Баяр, 2012, х.1265-1266) (§254) хэмээн Хөхөчос Цагаадай-д хандан сурган сэнхрүүлж байдаг.

Үүнээс гадна үлгэр домог, хэлц, ерөөл магтаал, дуу шүлэг, ураг хурим, ёс заншил, шашин шүтлэг, ав хоморго зэрэг зан үйлдэхийн сүүний тухай шууд буюу дам мэдээлэл элбэг байдаг. “Молом тойн эхийн ачийг хариулсан” гэх бурхан шашны сургамжит үлгэрт Молом тойн эхийнхээ ачийг хариулахын тулд тамд унасан эхээ зовлонгоос аврах гэж үлэмж бэрхшээлийг даван туулаад, эхээ тамаас гаргаж чадсан боловч ээжийнхээ нэг л шөнийн өндийж хөхүүлсэн ачийн хариу төдий байсан гэдэг сургаал, эх хүн хөхөөрөө хүүхдийнхээ сүнсийг дуудах дом шившлэг, шинэ бэрийг сүүтэй будаагаар амдах ураг хуримын ёс заншил болон эхийн цагаан сүүний ач хариулах зан үйл, алсын замд зорих хүний зөв талын дөрөөнд сүү дусаан аян замдаа саад тотгоргүй байхыг бэлэгшээх заншил, сүү шимээ хайрладаг эх малыг унаж эдэлдэггүй бөгөөд сүү сайт эх малыг муулах худалдахыг цээрлэх ёс заншил, хээлтэй буюу нялх төлөө дагуулсан буюу чинэрсэн дэлэнтэй нялх үр лүүгээ яаран тэмүүлэгч ан амьтныг хороож хөнөөдөггүй цээр ёс гэхчлэн олон бий. Эхийн хайрыг цагаан сүүгээр нь төсөөлөн ухаарах Монгол сэтгэхүй, танихуйн ухамсарт цагаан өнгө бол сүүний өнгө, эхийн сүүний анхдагч дохио тусгал мөн.

⁶Лиү Жинсүө: 刘金锁/ liú jīn suǒ. Өвөр Монголын Монгол түүхийн эрдэмтэн.

Нүүдэлчдийн амьдрал ахуйд сүүг өнгөөр нь төлөөлүүлэн Цагаан (сүүн) Идээ хэмээн нэрлэн, идээ будааны дээж болгон эрхэмлэн дээдлэх танихуйн туршлагаас цагаан өнгө бол цэвэр ариун, охь дээд, эрхэм нандин гэдэг ухамсар ойлголт тархины сэрэл мэдрэхүй, сэтгэхүйд нөлөөлөн Монгол хүний хэл яриа, амьдрал ахуй, гүн ухаанд цагаан өнгийг эрхэмлэх, шүтэх, дээдлэх, бэлэгшээх заншил хэвшин тогтжээ.

2. Малын зүсэм заасан “цагаан” хэмээх үг хэллэг нь 2 удаа тэмээний зүсэмд, бус 17 тохиолдол нь адууны зүсэмтэй холбоотой хэрэглэгджээ. МНТ-д Торголын баяны дайр бор хоёр хүлэг, Бутанцар-ын гол даарьт годил сүүлт орог шунхул, Чилээтийн хурдан хув, Бэгтэр-ийн адуулж байсан шарга агт тан есөн морьд (түүний нэг нь дархи оготор хонгор), Боорчу-ын хурдан хув, орог шунхул болон бөгтөр хонгор, Тогтога-ын эсгэл халиун, Чингис хааны зост бор зэргээс бусдад нь цагаан зүсэм буюу цагаан өнгө хосолсон давхар зүсмийн морьд байна. Эндээс ажиглахад цагаан, шаргал хоёр зүсмийн морьдыг харьцангуй илүү дүрсэлсэн явдал нь юунаас шалтгаалав?

Сорхон Шарын Тэмүжинд унуулж дутаалгасан ам цагаан эрмэг хулагч бол ам цагаан хул зүсмийн гүү болохыг эм хүйс ялгах “-ч” бүтээвэр баталж байхаас гадна эрмэг гэх үгийг “Хорин нэгт тайлбар толь”-д “Унага төрөхгүй гүү морийг эрмэг хэмээмүй” (1979, х.72) гэсэн тайлбар давхар нотолж байна. Энд унагалдаггүй сувай гүүг унаж эдэлдэг байсан тэмдэглэл нь өмнө өгүүлсэн сүү шимээ хайрладаг эх малыг унаж эдэлдэггүй ёс заншлыг мөн давхар баталж байгаа юм. Энэ морь бол Тэмүжин-г дутаалгахад унуулсан морь болохоор хонины бэлчээрт унадаг номхон хашин морь биш, харин салхин гүйдэлтэй, хүчин чадал төгс хүлэг болох нь ойлгомжтой. Аюул зовлон нүүрлэсэн үед “хар амаар ороод цагаан амаар гарах” хэмээн бэлэгшээх харыг муу муухай, цагааныг сайн сайхан хэмээх гүн ухаан, сэтгэхүйн ул мөр юм. Бас эм хүйсийн сувай гүүгээр дүрсэлж байгаа нь хожим хойноос өсөн үржихийн бэлгэдэл сэтгэхүйг харуулсан найруулгын ур маяг байж болно. Мөн “Ам цагаан зүсмийг бас цорво цагаан ч гэдэг. Цорво цагаан гэдэг нь өвс хамж иддэг уран хоншоор нь цагаан өнгөтэй давхар зүсэм. Зарим хүмүүс ийм морийг мөнгө үмхэж төрсөн олз омгийг бэлгэдсэн сайн унаа гэж үздэг” (Бүрэнтөгс, эмх. 1999, х.39-41) соёл заншилтай холбоотой.

Тэмүжин Боорчу хоёр дээрэмдүүлсэн шарга агт тан найман морьдыг дээрмийн хүрэнээс үлдэж гарахад хойноос нь нэхсэн дээрэмчний цагаан морины шинж болбоос маш хурдан гүйдэлтэй ажнай хүлэг байсныг

дүрслэхдээ “Хойноос аран овор совор нэхэж айсуу. Нэгэн цагаан морьт хүмүүн уурга барьж ганцаар гүйцэж айсуу” (Баяр, 2012, х.200) (§91) гэж тэмдэглэжээ.

Дайр Усуны эвэрт үнүхүн цагааныг Антоон Мостаэрт⁷ номдоо “Козан “эвэртэй залуу азарга”, Пеллио “эвэртэй ишиг адил цагаан морь”, Хэниш нарын орчуулга алдаатай болсныг заагаад, “Цагаан ишиг шиг зүсэм бүхий “эвэртэй” морь байсан... Дундад үеийн Монгол хэлэнд үнүхүн гэдэг үг ишиг гэсэн утгатай байсан (Мукаддиматал-Адаб толийн 382а)... Мал амьтны толгойд ургадаг эвэр бус харин магнайн хэсэгт үүссэн хатуу сайр эвэр юм” (2010, х.44-45) гэж ойлгожээ. Хишигбат “Эвэрургасан цагаан морь” (2001, х.36), Хуасай Дугаржав “Үнэгэн (үнэгэ чонын) цагаан морь” (1984, х.59) гэж хөрвүүлжээ. Элдэнтэй, Ардаажав “Эвэрт үнүгүн (unügün) цагаан” (1986, х.303) гэж хөрвүүлээд “Үнүгүн цагаан хэмээх инү цагаан өнгөтэй ишиг. Үнүгүн цагаан хэмээх нэрт морины нэр болой. Үнүгүн мэт үнүгүн цагаан нэрт морь” (1986, х.305) хэмээн тайлбарлаж, Тайчууд Мансан “Эвэрт өнөгөн (onogon) цагаан” (2007, х.86) гэж хөрвүүлээд “Эвэрт гэдэг нь морины мундаа буюу магнай дахь ямар нэгэн тэмдэг-бөөм үс буюу хөхлийн зүйл, үүнийг эвэр гэв. Өнөгөн гэгч орчин цагийн Монгол хэлний ишиг болой.эвэрт ишгэн цагаан үстэй морь” (2007, х.102) хэмээн тайлбарлажээ. Ш.Гаадамба “Эвэрт ишгэн цагаан морь” (1990, х.71), Д.Цэрэнсоднам “Эвэрт ишгэн цагаан” (1993, х.86) гэж хөрвүүлээд “Эвэрт ишгэн цагаан гэдэг нэртэй морь” (1993, х.336-337) гэж тайлбарлаж, Ш.Чоймаа “Эвэрт үнэгэн цагаан” (2011, х.66) гэж хөрвүүлээд “Ишгэн цагаан” (2011, х.66) хэмээн тайлбарлажээ. С.Жамбалдорж “Унаган цагаан” (1996, х.223), Н.Бөххад “Сахлагтаа эвэртэй, үнэгэн (үнэгэ чонын) шинж бүхий цагаан морь” (2010, х.211) хэмээн ухаарсан бол “Монгол зан үйлийн нэвтэрхий толь”-д “Сахалтай адууг эрт цагт Монголчууд эбэрт гэдэг” (Бүрэнтөгс, эмх. 1997, х.150) хэмээн тэмдэглэжээ. Энэхүү “үнүхүн” гэдэг үгийг үнэг (үнэгэ чонын), унага (унага даага) биш ишиг хэмээн ойлгож болохыг МНТ-ны Хятад ханз үсгээр галигласан эхийн хажуугийн орчуулагд “Ямааны ишиг”, “Хорин нэгт тайлбар толь”-д “Ишгийг бас өнүх (onuxu) хэмээмүй” (1979, х.150) мэтийн тайлбар зүүлт баталж байна.

Адууны нэршлийг “1. Нас шүдээр нь ялган нэрлэх, 2. Хүйс чанараар нь ялган нэрлэх, 3. Өнгө зүсмээр нь ялган нэрлэх (дан ба давхар зүсэм), 4. Төрц байдлаар нь ялган нэрлэх, 5. Алхаа гишгэгдлээр нь ялган нэрлэх, 6. Зан араншингаар

⁷Антоон Мостаэрт: Antoine Mostaert (1881-1971). Монгол эрдэмтэн, Католик шашны санваартан.

нь ялган нэрлэх, 7. Уналга хэрэглээний байдлаар нь ялган нэрлэх, 8. Нутаг усаар нь ялган нэрлэх, 9. Эзнийх нь нэрээр ялган нэрлэх, 10. Им тамгаар нь ялган нэрлэх, 11. Алдаршуулан цоллож нэрлэх” (Дамвизалцан, эмх. 1997, х.136-158) гэх мэтээр 11 зүйлд ангилснаас авч үзвэл “эвэрт” гэдэг нь төрц байдлыг заасан шинжтэй, “үнүхүн” бол зан араншинтай холбоотой шинжийг өгүүлсэн болно. Энд зээрийн ишиг, янгирын ишиг, ямааны ишигний зан ааш нь цовоо цолгин, үсэрч цовхчсон, хөнгөн гавшгай шинжээр хүлгийнхээ “толгойгоороо наадаж тосноосоо булхдаг, сүүлээрээ наадаж сүүдрээсээ булхдаг” зан араншинг нэрлэжээ. Мөн салаа туурайтай мал амьтны туурайн дээд хэсэгт ургах хоёр ширхэг жижиг эвэрлэг бодис—бэрви нь битүү туурайтай мал амьтанд тэр болгон заяадаггүй ховор тохиолдол болохыг адуун соёлын баялаг өвийг хадгалсан Монголчууд эрт цагаас адууг дасган маллаж, анхааран шинжиж, галбир шинжийг нь хураан дүгнэж иржээ. Өвөр Монголын Баарин нутагт “Адууны сахлагийн төвд ургасан ганц ширхэг жижигхэн хатуу эвэрлэг зүйлийг бэрви гэдэггүй, харин “эвэр” гэдэг. Тэр нь урт, бүдүүн байх тусам шандаст сайн хүлгийн шинжийг бүрдүүлсэн “найман туурайт ажнай” хэмээн бэлэгшээдэг ба иймэрхүү шинж нь толгой бие том, дөрвөн мөч бүдүүн, сахлаг урт, дэл сүүл шингэвтэр, тар хүч сайтай, хурдан жороо явдалтай моринд илүү тохиолддог байсан” (ярилцлага) хэмээн дээр үеийн буурлуудын ярианаас сонсож, өөрийн нүдээр харж, унаж эдэлж явсан удам залгасан адуучин Ринчинсүрэнгийн Баатарсүх хуучилж билээ. Үзэмчин нутагт бас иймэрхүү хууч яриа байдаг тухай Н. Бөххад “МНТ-ны шинжлэл” номдоо дурдсан байдаг. Тиймээс эвэрт үнүхүн цагаан бол Увас Мэргидийн ахлагч Дайр Усуны язгууртан гарал, зэрэг хэргэмийг тодорхойлсон, сахлагтаа эвэр ургасан “найман туурайт”, янгирын ишиг мэт хад чулуу, бэрх бартаанд даацтай, хөнгөн шаламгай хөдөлгөөнтэй, цагаан зүсмийн хурдан жороо явдалтай ажнай сайн хүлэг хэмээн ойлгож болох юм. Бас жороо явдалтай морь, луусыг ихэс дээдэс хүний унаа хүлэг болгон хүндэтгэл илэрхийлж байсныг “Зуун лангийн жороо луус” гэдэг ардын дуунаас мэдэж болно. Энэ дуу Богд Хаант Монгол Улс (1911-1919)-ын төрийн дуулал байсан гэлцдэг.

Чингис хааны ам цагаан хул морь нь байлдааны хүлэг тул хурд хүч ихтэй, ус өвсгүйд өл даадаг, армаг омоглон шинжийг бүрдүүлсэн нь маргашгүй, мөн ам цагаан шинж нь дээр өгүүлсэнтэй адил олз омгийг бэлгэдсэн бэлгэдэл утгатай бөгөөд хаан хүний унаж байгаа хүлэг

учраас байр суурь, хүндлэл дээдэллийг илэрхийлж байгаа нь лавтай. Их Цэрэн-ний Мэргидэй цагаан болон ам цагаан хээр хоёр морины шинжийн хувьд дайн байлдаанд унадаг болох нь тодорхой учраас хүч дорвитой, өл даадаг, хурдан шаламгай агт хүлэг мөн. Хабал хааны хөвгүүн Хулан Баатар-ын хүү Их Цэрэн бол язгууртан дээдэс гаралтай учраас олз омгийг бэлгэдсэн, эрх дарх, хүндлэл дээдэллийн илэрхийлэл болсон унаа хүлэгтэй байжээ. Худалдаачин Асан-ны унаж явсан цагаан тэмээ бол холын замд тэсвэр даацтай, хүч чадалтай байхаар барахгүй хөрөнгө чинээ, нийгмийн байр суурь, язгуур давхаргын илэрхийлэл байх магадлалтай. Өгээлүн эх яарч сандран шөнө дөлөөр тэргэнд хүлж явсан цагаан тэмээ бол тар тамиртай, хөлшинд зүтгэлтэн явдаг, сэргэг газарч шинжтэй байхаас гадна ихэс язгууртан дээдэст зориулсан хүндэтгэл бэлгэшээл, нэр хүнд, байр суурийг илтгэж байгаа унаа хөлш юм.

Монгол үндэстний түүх сурвалж, аман зохиол, соёл заншил, шашин шүтлэг зэрэгт цагаан зүсмийн мал амьтдыг хэрхэн дүрсэлснийг шинжилсүгэй. Дээр өгүүлсэн Монголчуудын дөрвөн цагийн хуримын ёс заншил дахь ер есөн цагаагч гүүний сүүн цацал, “Хулгайч хүний хусан урга хугартугай, хун цагаан адуу адуу минь энх мэнд хонотугай, өшөөт хүний өргөсөн урга хугартугай, өглөө бүр өндгөн цагаан адуу минь энх мэнд хонотугай” (Сампилдэндэв, эмх. 1987, х.343), “... Уулнаас их/ Цагаан гэртэй болтугай./ Одноос олон/ Цагаан малтай болтугай.” (Булаг, эмх. 1995, х.174-175) гэх мэтийн жишээ баримт арвин бий. Бөө мөргөлийн зан үйлд “Цагаан зүсмийн адууг онгод тэнгэр, сахиулсны унаа хүлэг хэмээн тэнгэрийн тайлга тахилгад бэлтгэх өндгөн цагаан” (Сайнжиргал, 2001, х.73-74)-аас ялгаан цээрлэх болсноор саарал зүсэм хэмээгээд “янзган зоотой саарал” (ардын дуу), “шувуун саарал” (уран зохиол), “Сүх-ийн саарал” (морин хуурын ирэлттэй холбогдсон домог) гэж нэрлэдэг. Үүнээс үзвэл “Зүсмийн бэлгэдэл нь нийгмийн язгуур давхаргын угсаатны, газар нутгийн, малын үүлдэр угсааны, өсөх үржихийн олон бэлгэдэл утгыг илэрхийлдэг. ...цагаан зүсмийн бэлгэдэл нь мал сүргийн ах дээж, эх түрүүт, ...өсөн үржихийг, ...тайван тогтуун аз жаргалт амьдралыг зөгнөх (Дулам, 2007, х.16) болсон бөгөөд унаш хөлшинд хүч чадалтай, тэсвэр даацтай, хурдан шалмаг явдалтай байдаг. Түүгээр үл барам олон мянган жилийн нүүдэлчин ахуй амьдралын танихуйн туршлагаасаа “хонь харлаж, үхэр цайж, адуу цоохордож барагдана” гэж дүгнэн гаргаад цагаан зүсмийн мал амьтад урт удаан наслах онцлог шинжийг таньснаас

шалтгаалан бэлэг сэлт хүргэх, зан үйлд хэрэглэх, эдэлж хэрэглэхдээ голдуу цагаан зүсмийн мал амьтдыг илүү эрхэмлэн сонгох болжээ.

3. Оноосон нэрд орсон “цагаан” хэмээх үг хэллэгийн Чонос овгийн Нэгүдэй Цагаан-Ува (Гоо), Горулас аймгийн Чонаг (Чогос) Цагаан бол хүний нэр, Цагаан Татаар бол овог аймгийн нэр болох юм. Монголчуудын хүний нэрийн тухай соёл заншилд Цагаан Гоо нь Баргуужин Гоо, Монголжин Гоо, Борогчин Гоо нартай адилаар нутаг ус, овог аймагтаа нэр алдартай гоо сайхан царайлаг хүн байснаас ийм нэр цолтой байсан байх бололцоотой. Чонаг (Чогос) Цагаан-ны хувьд Горлос аймгийн оршин амьдарч байсан уул усанд нь цагаан хайрхан, цагаан даваа, цагаан булаг, цагаан нуур гэх мэт нэртэй газрууд байснаас шалтгаалсан байж болох, эсвэл цонхигор шингэн цагаан царайтай байснаас хоч нэр авсан байх магадлалтай юм. Цагаан Татар нь байнгын Цагаан Хэрэм (Great Wall) хавь ойрхон аж төрөн нутаглаж байсан болохоор ийм нэрийдлийг авсан байж болох, эсхүл дээр өгүүлсэн Цагаан Дайчуулын нэрээс ирэлттэй байж болох юм. Энэ тухай тэмдэглэл МНТ-ны §132-д тэмдэглэсэн Вангин Чинсан Татаарын Мэгүжин Сүүлт тэргүүтнийг Монгол нутгийн гүн уруу нэхэмжилсэн үйл явдлаас мэдэж болно. “Цагаан өнгө нь хүний нэр болохдоо өөд эсрэг, гоо үзэсгэлэн, сайн сайхан зэрэг бэлгэдлийн санааг шингээсэн бололтой. Цагаан өнгө нь орчин үеийн Монгол хүний нэрд нэгэн адил эрхэмлэгдэж” (Пунсаг, 2011, х.61) хэрэглэгдсээр байна.

4. Шилжсэн утгын зүйлд §63-ийн “Есүхэй худ, би энэ шөнө зүүдэн зүүдлэв би. Цагаан шонхор наран сар хоёрыг атган нисэж ирж гар дээр минь туув. Энэ зүүдэн нияан хүмүүнээ өгүүлрүүн: <наран сарыг харж үзэгдэн бүлгээ. Эдүгээ энэ шонхор атгаж авчирч гартур мину туув, цагаан буув, ямар л сайн үзүүлмүү> хэмээж, Есүхэй худ, энэ зүүдэн минь чамайг эл хүүгээ удирдаж ирэхүйеэ үзсэн ажгуу. Зүүдэн сайн зүүдлэв. Юун зүүдэн аху? Та Хиад иргэний сүлдэр ирж заасан ажгуу” (Баяр, 2012, х.99-101) гэх хэсгийн “цагаан буув” гэдгийг Хишигбат “Эдүгээ энэ цагаан шонхор нар сарыг авч миний гар дээр ирсэн ину эрхгүй сайн бэлгэ байнам” (2001, х.15), Хуасай Дугаржав “Одоо цагаан шонхор шувуу наран сарныг атган авчирч, миний гар дээр буусан нь ямар л сайн бэлгэ тэмдгийг үзүүлэх вэ гэж бодож байсан билээ” (1984, х.18), Элдэнтэй, Ардаажав “Цагаан буув” (1986, х.117) гэж хөрвүүлээд “Сайн бэлгэ тэмдэг буув, ирэв” (1986, х.118-119) хэмээн тайлбар хийжээ. Тайчууд Мансан “Наран сарыг бид нүдээр үздэг билээ, гэтэл наран сарыг

шонхор атган ирж гар дээр минь буув” (2007, х.19-20), Ш.Гаадамба “Нар сарыг шонхор шувуу атгаж миний гар дээр буух нь гайхалтай, ямар сайн бэлгэ тохиол учрах болов гэж би бусдад хэлсэн бөлгөө” (1990, х.70), Д.Цэрэнсоднам “Цагаан гэрэл буув” (1993, х.50), Ш.Чоймаа “Цагаан буув” (2011, х.27) хэмээн хөрвүүлээд тайлбар хийгээгүй орхисон бол М.Ууганбаяр “Сэтгэл баясах бахдах” (Ууганбаяр, 1996, х.78) гэж ухаарчээ. Зохиогчийн ойлгож байгаараа энэ хэсэгт цагаан шонхрыг болбол хоёр ч удаа “туув” (суув) хэмээж бичиж байгаагаас үзвэл “туув” болон “буув” хэмээх хоёр үгийн хэрэглээ, утга, үүрэг маш нарийн ялгаатай байсны нэгэн гэрч мөн. Бас нэг баримт нотолгоо нь Монголчууд ямар нэг үйл хэргийн болж бүтэх эсэхийг урьдчилан мэдэх зорилгоор мэргэ төлөг үзэх, төлөг татах, төлөг тавих, төлөг орхих, төлөг буулгах буюу өөрийн зөн совингоороо сэрж мэдэрдэг ёс уламжлалтай учраас сайн муу үр дагаврыг цагаан төлөг буух, хар төлөг буух, цагаа совин татах, хар совин татах гэхчлэн ярьдаг. Дай Цэцэн энэ зүүдээ “ямар л сай үзүүлмүү” гэж хүн амьтанд зүүдээ ярьж сонсож, өөрөө тайлан уншиж, сайн үр дагавар баттай дагуулахыг урьдчилан мэдэж байсан болохоор зурхай зурж, төлөг тавиагүй гэдэг нь тодорхой. Тиймээс цагаан шонхор шувууг “буув” гэдгээр ухаарч ойлгох нь хэлний зүйд тохирохгүй, тэр ч байтугай “цагаан төлөг буусан” биш, харин “цагаан совин буув, цагаан совин татав” хэмээн ойлгох нь зөв юм. “Монголчууд бэлэг шинжиж, бүх юмны нарийн нууцыг тайлдаг” (Пунсаг, 2013, х.114) их ухаантай ард түмэн болохыг МНТ-ны олон газар дүрсэлсэн байдаг. Жишээлбэл: §80-д морины эмээл оломлосоор, хөмөлддрөглөсөөр мултарсан хийгээд шугуйгаас гарах замыг хошлонгийн чинээ цагаан гүр бөглөсөн байтал зориуд шугуйгаас гараад Тэмүжин Тайчуудад баригдсан явдал. §101-д Бүртэ Үжин-ний сууж дутаасан тэрэгний тэнхлэг хугарч, Бүртэ Үжин Мэргидэд баригдсан явдал. §158-д Найманы Хүчүгүдийн Буйруг ханы Йэди Тублуг ноён зугтах үеэр эмээлийн олом тасарч, дараа нь Буйруг Хан сөнөөгдсөн явдал. §245-д Тэмүгэ Отчигин болон Тэв Тэнгэр хоёр гэрт барилдаж автал Тэв Тэнгэрийн малгай голомтын тэргүүнээ унаж, Тэв Тэнгэр амиа алдсан явдал. Эдгээр сонирхолтой дүрслэлүүдээс §101, §158, §245-д сөрөг муу дохио, хар зөн совин ажиглагдаж байгаа бол §80-д эерэг дохио, цагаан зөн совин тусгалаа олж байна. Үүний нэг адилаар §63-ийн цагаан шонхор наран сарыг атган нисэж ирсэн нь арга билгийн нэгдэл, Тэмүжин Бүртэ хоёр ураг тогтохын шинж бэлгийг үзүүлсэн цагаан зөн совин билээ.

МНТ-д “Гэгээн цагаан өдөр”, “Өрх тотгын гэгээ”, “Харанхуй шөнө”, “Түхшин болж айсуу”, “Бараан болтаж”, “Гэрэл ширэл өдөр гийн бүхий”, “Эрүбарү өдөр гийн бүхий”, “Шөнө дүлэж өдөр гийвээс”, “Өдөр гийж гэгээн болж”, “Өдөр гийн барваас”, “Өдөр гийгүүлэн”, “Өдөр гэгээн болгож”, “Хар шөнө”, “Гэгээн өдөр”, “Өдөр шард” гэх мэтийн гэрлийн хүчлэлцээр цагийн хуваарийн хэм хэмжээсийг тодорхойлсон үг хэллэг олон байгаагийн учир шалтгаан нь ан гөрөө, мал малжлаар ахуй амьдралаа болгож, байгаль дэлхийтэйгээ шүтэлцэн оршдог нүүдэлчид гэрэл сүүдэр хоёрын солигдлоор өдөр шөнийн хоорондох цагийн хуваарийг маш нарийн ялгаатай мэдэрч чаддаг танихуйн туршлагатай шууд холбоотой юм. Эдгээр үг хэллэгээс тухайн үед нарны гэрлийн чанга сулын хүчлэлцээс шалтгаалан тэнгэрийн хаяа хувирч өөрчлөгдөхөөр дамжин үүр шөнийн зааг, үдэш оройн заагийн нарийн ялгамжааг магадлан тогтоож байсныг мэдэж болно. Хүний танихуй дахь “Өдөр шөнийн ялгааны тухай ойлголтоос өнгөний тухай танилт гүнзгийрч, ахуй байгалийн тухай танилт ухамсар байснаасаа нэг хэрэг будсын шинж чанарыг илтгэсэн бэлгэдэл утгатай болж, нийгэм соёлын хүрээнд нэвтэрсэн” (Пунсаг, 2011, х.54) цогц ойлголтын цогц мэдлэг болж бүрэлддэг юм. МНТ-ны “Тайчууд Онон-ны эрэг дээр хуримлалдаж наран шингэвээс тархав. ...Тайчууд хурж ирж, өдөр мэт саруул Онон-ны түнийг бэдрэв. ...Сорхон Шар өгүүлрүүн: «Тайчууд хөвгүүд та гэгээн цагаан өдөр хөвчин хүн алдав. Эдүгээ харанхуй шөнө хэр олхуун?»” (Баяр, 2012, х.167-174) (§81) хэмээн тэмдэглэснээс харахад Тэмүжин хав харанхуй орчинд нуугдахаас “өдөр мэт саруул” орчинд нуугдах нь нэн илүү ухаан самбаа, зориг тэвчээр, тамир сүлд шаардагдах учраас түүнийг “хар тэргүүт” “харцас”-аас өөр “тэнгэр заяат”, “хан язгуурт” болохыг магтан товойлгох зорилготой хэлний илтгэх ур маяг болно. Үүгээр барахгүй МНТ-ны хэлэнд хүйсийн ай маш чанга зохицолтой байдгаас “Шөнийг маш тодорхой эм хүйсийн “-tai/tei” хэлбэрт зохицуулан эмээр илтгэсэн байна” (Бүрэнбат, 1993, х.7). Иймээс тэмүжин-нийг эм хүйсийн илэрхийлэл болсон “хар шөнө” биш түүний эсрэгцэл “гэгээн өдөр” мэт нөхцөлд нуусан болохыг тодотгох зорилготой тухайн орчны онцгой хэл найруулга, сэтгэхүйн онцлог мөн гэж бас үзэх ёстой. Иймээс энэ “гэгээн цагаан өдөр” гэдэг хэллэг нь “харанхуй шөнө” гэдэг хэллэгийн эсрэгцэл болж, гэрэл гэгээтэй цаг гэсэн утгыг илтгэж, МНТ-ны хэл, найруулгад “гэгээн, цагаан, цэгээн” нь утга нэгдмэл байна.

“Цагаанаа цацваас, хард хахваас” гэдэг үг

хэллэгийг эрдэмтэд янз янзаар ухааран ойлгож бичиж тэмдэглэжээ. Антоон Мостаэртаас Козин, Хэниш, Пеллио нарын орчуулгыг харьцуулан шинжлээд “Цагаанд цаца-, хард хаха- хэмээн орчуулах нь зүйтэй. ...цагаан гэдгийг унд, өөрөөр хэлбэл, айраг болон сүүнээс гаргаж авдаг бусад умд...хар гэдэг үг бүхэл хоол хүнс, ялангуяа махыг нэрлэсэн гэдэг нь илэрхий” (2010, х.60-61) хэмээжээ. Хишигбат “Чи одоо энд суувч Тэмүжин биднийг хүний тоонд бодохгүй, хэрэв эцэг өтлөөд миний дээд өвгийн зовнин зүдэрч хурааж олсон албат ардыг юунд надаар хамаргах ажуй” (2001, х.64) гэж, Хуасай Дугаржав “Цагаан идээнд цацаж хар маханд хахах” (1984, х.107) гэж, Элдэнтэй, Ардаажав “Цагаанаа сацваас, хард хахваас” (1986, х.482) гэж хөрвүүлээд “Хүний идээ идэж чадахгүй болж үхэхийг зүйрлэн өгүүлэв. Үхэх гэсэн санааг ил хэлсэнгүйгээр сүү увал цацаж, мах идвэл хахдагаар зүйрлэв” (1986, х.486) хэмээн тайлбарлаж, Тайчууд Мансан “Цагаан идээнд зангирч, хар маханд хахваас” (2007, х.149) гэж хөрвүүлээд “Цагаан идээнд зангирч, мах тосонд бөглөрвөөс гэсэн үг болой. Энэ хоёр үг цөм нас барж бие өнгөрөх гэсэн санаа бүхий үг болно” (2007, х.158) хэмээн тайлбарлажээ. Ш.Гаадамба “Цагаан идээнд цацаж, хар маханд хахвал” (1990, х.124), Ц.Цэрэнсоднам “Цагаанаа цацваас, хард хахваас” (Цэрэнсоднам, 1993, х.128) гэж хөрвүүлээд “Нас барахыг өгүүлжээ. ...өтлөө болсон өвгөдөө хонины уураг сүүлээр хахааж алдаг байсан, ...хүний аманд чулуу чихэж цаазалдаг ёс заншлын учир холбогдолтой байж болох юм” (1993, х.184-185) хэмээн таамаг дэвшүүлжээ. Бүрэнбат “Энэ өвөрмөц хэллэг бол үнэндээ “гаалал төгсөх, тэнгэрт гарах, нүд аних, үүл далдлах, жанч арилжих, амьсгал хураах, яс амрах, хадан гэрт очих ...” гэх мэтийн хэллэг лүгээ адил шинжтэй “үхэх” гэдэг утгыг заасан хэлц болох нь тухайн хэлний орчноосоо тодорхой мэдэгдэн бий юм” (Бүрэнбат, 1995, х.60) гэж тушаагаад “Монголчуудын соёл түүх, зан үйл, амьдрал ахуйн олон талаас ажиглалт хийхэд “эртний Монголчууд ер нь ‘хахах’ ба ‘цацах’-ыг алагдал ба үхэл лүгээ холбон сэтгэдэг байсан бөгөөд “хахаж цацвал” үхдэг ёстой, “хахуулж цацуулж” үхүүлдэг хуультай байсан юм байна” (1995, х.62) хэмээн шинжлэн тодорхойлжээ. Ш.Чоймаа “Цагаанд цацваас хард хахваас” (Чоймоо, 2011, х.109) гэж хөрвүүлээд “Нас өндөр болж, дээдсийн ёсоор үхвээс” (2011, х.110) хэмээн тайлбарлажээ. А.Пунсаг “Цагаанаа гэдэг нь сүү буюу ундааны төрлийг, хар гэдэг нь мах буюу хоолны төрлийг ерөнхийлөн зааж, хоол унд юу ч идэж ууж чадахгүй чухамхүү “цагааныг увал цацаж, харийг идвэл хахаж” үхэхийг цээрлэсэн

хэвшмэл хэллэг мөн” (Пунсаг, 2013, х.234) хэмээх тайлбар хийжээ. “Хорин нэгт тайлбар толь”-д “Будаа ус, мөгөөрсөн хоолойд орж, ам хамраас гаран ханиахуйг цацмуй хэмээмүй” (1979, х.751)-гээд мөн “Загасны хагадас, ясны зэргийн юм хоолойд торж залгиж болохгүйг хахмуй” (1979, х.304) хэмээн тус тус тайлбарласан байдаг. Энэ тайлбарыг үндэслэвэл “цагаан” нь сүүн бүтээгдэхүүн идээ ундаа, “хар” ны ястай махны төрлийн хоолтой холбоотой мэт. Хүн нас өндөр болохыг дагалдан биеийн эд эрхтний үйл ажиллагаа доройтон уусан идсэн зүйлдээ хахаж цацах нь олширдог амьдралын жам ёс байдаг ч үүнтэй зэрэгцээд хүний ой тогтоомж, оюун ухаан муудан сайн муу үйл, үнэн худал мэдээллийг ялган салгаж чадахаа больж, зөв зүйтэй бодлого тогтож чадахгүй “хар цагааныг тонгоруулах” мунаг зөнөг болохыг заасан байж мэднэ. Монгол хүний ертөнцийг үзэх үзэлд “цагаан”-аар зөв зүйтэй сайн явдлыг, “хар”-аар бохир заваан муу явдлыг төлөөлдөг гүн ухааны хэвшсэн ойлголт байдгийг “хар цагааныг ялгах”, “хар санаа биеийг ороож, цагаан санаа талыг тойрно”, “уулын чинээ харыг туулайн чинээ цагаанаар”, “арван цагаан буян, арван хар нүгэл” гэх мэтийн хэллэгээс ухаарч ойлгож болно. Иймээс энэ хэллэгийн утгыг §167-ны тухайн найруулгын орчинд авч үзвэл, чамайг ухаан санаа эрүүл саруул, чадал тэнхээтэй байхад биднийг тоохгүй байна. Нэн хан эцэг таныг сайн муу үйлийн аль алиныг танихаа больж өтөлж зөнөх үед эцэг дээдийн байгуулсан улс орныг чинь эзэлж авна хэмээн ойлгож болно.

Дээрх задлан шинжилгээний явцаас “Үгийн утга нь олон жилийн туршид бүрэлдэн тогтдог түүхэн үзэгдэл бөгөөд үгийн утга бүрэлдэх нь хэл буй болсон цаг үеэс тасралтгүй үргэлжилж байдаг зүй тогтолтой үзэгдэл юм. Үгийн амин сүнс нь түүний утга бөгөөд бодит ертөнцийн хөгжил хөдөлгөөний нарийн зүй тогтлыг хэлнээ илэрхийлж байдаг нэгэн өвөрмөц ай болно.Үг нь тогтсон нэг утгатай байхаас гадна хэлний хөгжил, хэрэглээний явц, нийгэм соёлын хөгжлийн өөрчлөлтийг даган хувирч өөрчлөгдсөөр салбар салаа утгатай болдог байна.Үгийн утга нь хэдий олон салаа, салбар утгатай болсон ч үг нь үндсэн утгатайгаа заавал дам холбоотой байдаг байна” (*Орчин цагийн Монгол хэл*, 2008, 320-323). Байгаль дэлхийтэйгээ харилцах явцдаа ямар нэгэн далдын хүчин зүйл байдагт итгэдэг, бас түүнээсээ эмээн сүрддэг байсан хүн төрөлхтний язгуур сэтгэхүйд тэрхүү хүчин зүйлс нь өнгө зүсэм, зүг чиг, тоо хэмжээ, хэлбэр дүрс зэргээс хамааралтай хэмээн ухамсарладаг байснаас “Зан үйл, тайлгаа тахилга,

бөө мөргөлийн ёс заншилд цагаан өнгийн бэлгэдэл утга аяс нь илүү тодорхой ялгарч ирдэг” (Дулам, 2007, х.16) байна.

Судалгааны үр дүн

“Хорин нэгт тайлбар толь”, “Монгол үгний тайлбар толь”, “Монгол үсгийн дүрмийн толь”, “Монгол хэлний товч тайлбар толь”, “Монгол үсгийн язгуурын толь” зэрэг эл толь бичигт байгаа “цагаан” хэмээх үг хэллэгт дүн шинжилгээ хийгээд үндсэн утга болон бэлгэдэл утгаар хэрэглэгдэж байгааг мэдэв. МНТ-д давхардсан тоогоор нийт 39 удаа “цагаан” хэмээх үг илэрснээс үндсэн өнгөөр 9 удаа, малын зүсэмд 19 удаа, хүний нэрт 8 удаа, шилжсэн утгаар 3 удаа хэрэглэгдэж байгааг тодорхойлоод “Цагаан” хэмээх заншилт үг хэллэгт нь шулуун шударга, үнэнч цагаавар, бэрх бартаагүй, харш саадгүй, хялбар дөхөм, амар хялбар, этгээд гажуу, үнэн зөв гэх мэт шилжсэн утгаар хэрэглэгддэг бөгөөд цэвэр ариун, эрхэм дээд, хүндлэл бишрэл, гэрэл гэгээ, мандал бадрал, амар амгалан, өөд эсрэг, сайн сайхан, тайван тогтуун, аз жаргал гэх мэт бэлгэдэл утга, гүн ухааны үзэл баримтлал байдгаас гадна цагаан зүсмийн мал нь нийгмийн язгуур давхаргын илэрхийлэл, урт удаан наслах, мал сүргийн ах дээж, эх түрүүг, үүлдэр угсааны өсөн үржихийн бэлгэдэл санаатай болохыг тогтоов.

Дүгнэлт

Хүний байгаль нийгмийн амьдрал дахь танихуйн ухамсар, танихуйн үйл ажиллагаа, танихуйн туршлагад суурилсан цогц ойлголтоос “цагаан” хэмээх үгийн анхдагч дохио, эх дүр нь сүү буюу эх хүний сүү байсан гэдэг дүгнэлтэд хүрч байна. Эхийн сүүг эрхэмлэн дээдлэх ёс заншил нь эхийн эрхт ёсны им тамгын нэгэн гэрч мөн.

Утгын бүрдэлд үйлчлэх цогц ойлголт нь тухайн улс үндэстний оршин амьдарч байгаа бүс нутаг, байгаль орчин, ахуй амьдрал, ёс заншил, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний өвөрмөц үнэлэмж хандлага зэрэг хүчин зүйлийг хамарсан цогц мэдлэг юм.

Үгийн утга шилжих үзэгдэл нь үгийн язгуур утгыг хадгалсан утгын төвөөс холдон холдох тусам язгуур шинжээ алдаж, бусад олон утгын орны харьцаа холбоонд орших танихуйн цогц ойлголтын үзэгдэл бөгөөд танихуйн зүйрлэл, бэлгэдэл санаа мэт хүчин зүйл нөлөөлдөг.

Ашигласан материал

- Баатарсүх, Р. (2017,1,28). *Ярилцлага*, ӨМӨЗО, Баарин баруун хошуу, Баян-Эрдэнэ сум, Цагаан-Хөндий баг.
- Базаррагчаа, М. (1995). Монгол үгийн гарлыг мөшгөх нь, *III боть*. Улаанбаатар.
- Баяр, (2012). *МНТ (3 дахь хэвлэл)*. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо (ӨМАХХ).
- Бөххад, Н. (2010). МНТ-ны шинжлэл. Улаанбаатар.
- Булаг, эмх. (1995). *Монголчуудын галын тахилгын судар оривой*. ӨМАХХ.
- Бүрэнбат, (1995). ‘МНТ’ дахь ‘үхэх’-ийг заасан хоёр өвөрмөц хэлцийг шинжлэх нь, *ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1-р хугацаа*. Хөх хот.
- Бүрэнбат, (2003). Дундад үеийн Монгол хэлний <хүйсийн ай>-тай холбогдох зарим онцгой үзэгдлийг нарийвчлах нь, *Монгол хэл утга зохиол сэтгүүл, 5-р хугацаа*. Хөх хот.
- Бүрэнтөгс, эмх. (1997). Монгол зан үйлийн нэвтэрхий толь, *I боть*. Өвөр Монголын Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Хэвлэлийн Хороо (ӨМШУТМХХ).
- Бүрэнтөгс, эмх. (1999). Монгол зан үйлийн нэвтэрхий *II боть*. ӨМШУТМХХ.
- Гаадамба, Ш. (1990). МНТ. Улаанбаатар.
- Гэрэлт, Н. (2002). ‘МНТ’-д гардаг ‘цагаан хар улаан шар хөх’ зэрэг үгэнд агуулагдаж байгаа өнгийн соёлын онцлогийг шинжилж үзэх нь, *Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан, 3-р хугацаа*. Хөх хот.
- Дамбижалцан, Х. эмх. (1997). Монгол зан үйлийн зүй. ЛюуНингийн Үндэстний Хэвлэлийн Хороо.
- Дугаржав, Хуасай. (1984). МНТ-ны харгуулан хянасан дэвтэр. Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо (ӨМСХХ).
- Дулам, С. (2007). Монгол бэлгэдэл зүй, *II боть (2 дахь хэвлэл)*. Улаанбаатар.
- Дэлгэр, Одон, (2001). МНТ-ны Найруулга жич түүний бэлгэдэл дүрийн судлал. Үндэстний Хэвлэлийн Хороо (ҮХХ).
- Жамбалдорж, С. (1996). Морин эрдэнэ. Улаанбаатар.
- Лиү Жинсүө, эмх. (1980)*. Арван буянт номын цагаан түүх. ӨМАХХ.
- Мандах, Ү. (2006). Монгол хэлний заншлын судлал. ҮХХ.
- Мансан, Тайчууд. (2007). Шинээр орчуулж тайлбарласан МНТ (*2 дахь хэвлэл*). ӨМШУТМХХ.
- Мостаэрт, Антоон. орч. (2010). МНТ-ны зарим үг хэсгийн тухай. Улаанбаатар.
- Нансалмаа, Н. Долгор, С. (2014). Танихуйн хэл шинжлэл. Улаанбаатар.
- ӨМАХХ. 1979. Хорин нэгт тайлбар толь.
- Пунсаг, А. (2011). МНТ дахь ёс заншлын судалгаа. Улаанбаатар.
- Пунсаг, А. (2013). МНТ дахь ёс заншил зан үйлийн тайлбар толь. ӨМАХХ.
- Сайн, (1990). МНТ дахь олон давхраат соёл. ӨМСХХ.
- Сайнжаргал, (2001). Монгол тахилга. ҮХХ.
- Сампилдэндэв, Х. эмх. (1987). Монгол ардын аман зохиолын чуулган. Улаанбаатар.
- Улаанбаатар. (2004). Орчин цагийн Монгол хэл.
- Ууганбаяр, М. (1996). *МНТ-ны зарим үг хэллэгийн тайлбар, магистрын ажил*. Улаанбаатар.
- Хишигбат, (2001). Хишигбатын орчуулсан Юан улсын нууц товчоо (*2 дахь хэвлэл*). ӨМАХХ.
- Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар Толь. Улаанбаатар
- Цэдэв, Д. (2002). МНТ-ны бэлгэдэл зүй. Улаанбаатар.
- Цэрэнсоднам, Д. (1993). МНТ-ны орчуулга тайлбар. ҮХХ.
- Цэцэнцогт, (1988). Монгол үгсийн язгуурын толь. ӨМАХХ.
- Чоймаа, Ш. (2011). МНТ эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. Улаанбаатар.
- Шагж, (1994). Монгол үгний тайлбар толь (*2 дахь хэвлэл*). ҮХХ.
- Шагж, (1997). Монгол үсгийн дүрмийн толь (*2 дахь хэвлэл*). Хөх хот.
- Элдэнтэй, Ардаажав, (1986). МНТ-ны сийрүүлэл тайлбар. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо.
- Элдэнтэй, Оюундалай, Асралт, (1991). МНТ-ны зарим үгийн тайлбар. ҮХХ.